

**МОНГОЛ ХЭЛНИЙ -Н ДЭД БҮТЭЭВРИЙН
ҮҮРЭГ, НАЙРУУЛГЫН ОНЦЛОГ**

М. Энхжаргал*

Түлхүүр үг: бүтээвэр зүй, монгол хэл, үгийн утга

Бүтээврийн түвшинд илрэх дэд бүтээврийн тухай

Хэл шинжлэлд дэд аялгуу, дэд өргөлт, дэд утга гэх зэрэг олон ойлголт байдгийн нэг нь энэхүү бидний авч үзэж байгаа “дэд бүтээвэр” хэмээх ойлголт юм. Субморф буюу дэд бүтээвэр нь хэлний бүтээврийн түвшний дэд нэгж бөгөөд тухайн үндэснээ дэд бүтээврийг нэмж залгавч утга төдий л нэмэгдэхгүй, зөвхөн үл ялих найруулга, хэрэглээний ялгаа бий болгож буй хэсэг бүлэг бүтээврийг хэлнэ. Энэхүү бүтээврийн түвшинд илрэх дэд нэгжийг нэрлэсэн нэршил нь янз бүр байна. Үүнд: Е.А.Земская, Е.С.Кубрякова “дэд бүтээвэр”(субморф), Н.М.Шанский “залгаваранцар”(аффиксоиды), Д.С. Ворт “утгын агуулгагүй бүтээвэр”(не семантическоесодержание морфем), В.В. Лопатин “жийрэг, илүүдэл маягийн бүтээвэр”(“избыточные” с формальной морфем), Г.О. Винокур “үндсийн хувилбар” (передюювариацию)-г үүсгэж байгаа бүтээвэр”, А.И. Моисеев “хуурмаг бүтээвэр” (квазиморфема) гэж тус тус ялгаатай боловч уг дэд бүтээврийн үндсэн шинж, утгыг агуулсан нэрээр тодорхойлжээ. Монгол хэлний дэд бүтээврийг тусгайлан судалсан бүтээл ховор бөгөөд энэ тухай өөрсдийн санал дүгнэлтийг М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, оросын монголч эрдэмтэн Г.Ц.Пюрбеев нарын эрдэмтэд дэвшүүлсэн байдаг.

Оросын эрдэмтэн В.Г.Чурганова¹ 1967 онд хэвлүүлсэн нэгэн өгүүлэлдээ дэд бүтээврийн шинжтэй хэлний үзэгдлийг “бүтээвэр-авиалбарзүйн ялгаварт хэсэг” гэж нэрлэжээ. Тэрээр “Сүүлийн үед дэд бүтээврийг үгийн хэлбэрийн бүтээвэр-авиалбарзүйн ялгаварт хэсэг(морфонологический релевантные отрезки слов) гэж үзэж байна. Жишээ нь: *зубец, чепец* гэх мэт үгийн *-ец, -ц* гэсэн багасгасан утгатай дэд бүтээврийг авч *зубчик, чепчик* (бяцхан шүд, бяцхан оройвч) гэсэн үгсийг бүтээж байна” гэжээ.

Орос хэлний бүтээвэр судлаач Е.А.Земская² “Авианы бүтцээр ба янз бүрийн сэлгэцээр тухайн бүтээврээс ялгарч байвч утгын ялгаа гаргахгүй байгаа тийм хэсгийг

* Монгол Улсын Боловсролын Их Сургууль

¹ В.Г.Чурганова, “О предмете и понятиях фонеморфологий”(Известия АН СССР, Серия литературы и языка. 4. 1967. стр. 366-367)

² Е.А.Земская, “Современный русский язык”, М., стр.81-82.

дэд бүтээвэр (субморф) гэнэ. Дэд бүтээврийг өгүүлбэрийн бүтцээс ялгах нь чухал. Учир нь дэд бүтээвэр нь үг бүтэх ёсонд (слово образовательное поведение) нөлөөлдөг” гээд *ларь-ларец, сын-сынок, нож-ножик* гэх мэт үгэнд орсон *-ец, -ок, -ик* гэсэн дагавруудаар жишээ авсан байна. Харин *чепец-чепчик, чулок-чулочек, колпак-колпачок* зэрэг үгсэд орсон *-ик, -ок* дагаврыг үндэс бүтээхэд оролцож байгаа дэд бүтээвэр хэмээн ялгажээ.

Д.С Ворт³ Олон улсын хуралд тавьсан нэгэн илтгэлдээ: “Бидний бодоход одоогийн бүтээврийн бүтэх хэсэгт олон ойлголт багтдаг. Үүнд: бүтээврийн хэсгүүд, авиалбарзүйн хэлбэртэй байх, утгын агуулгагүй бүтээвэр гэх мэт” гэжээ. Эдгээрээс “Утгын агуулгагүй бүтээвэр” гэдэг нь дэд бүтээврийн тухай дурджээ.

Дэд бүтээврийн тухай Оросын эрдэмтэд судалгааны ном, бүтээлүүддээ дээрх маягаар үзсэн бол О.С. Ахмановагийн тайлбар толийн 460-р талд: “*Субморфемный*” (анг.submorphemic) гэсэн үгийг “ Не дифференцированный на уровне морфем” буюу “бүтээврийн түвшинд утга үл ялгах бүтээвэр”⁴ хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлэн дэх дэд бүтээврийг тусгайлан судалсан судалгаа ховор бөгөөд М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, Оросын нэрт монгол судлаач Г.Ц. Пюрбеев зэрэг судлаачид өөрсдийн бүтээлүүддээ дараах байдлаар дурджээ.

Эрдэмтэн М.Базаррагчаа монгол хэлний гарал судлалын тухай “Та...хэмээх үе-утгалбар” өгүүлэлдээ га... үе-утгалбарын хийсвэр шинжийг тоочжээ. Ш.Туяа⁵ “Хэлбэрээрээ бүтээвэртэй адил боловч бүтээвэр биш үүсмэл үгийн хэсгүүдийг хуурмаг бүтээвэр (квазиморфемы) буюу гол бус бүтээвэр (субморфемы) гэж нэрлэх нь бий гээд суб-аренда, нем-ец зэрэг жишээг дурджээ”.

Б.Идэрбаяр⁶ “Төсөөт үгийг ойролцоо үг болон хувилбараас ялгах хэрэгтэй боловч энэ нь тийм ч хялбар зүйл биш юм. Жишээ нь: ая~уя, ховил~говил, гүн~гүнзгий, уудам~уужуу гэхэд ихэвчлэн авиа болон бүтээврийн сэлгэцээр үүссэн боловч утга нь төдий л ялгараагүй тул нэрлэвэр (номема), илэрхийлбэр (сомема)-ийн хувилбар болно. Ийм хувилбарыг авианы болон утгын холбогдол бүхий сэлгэц хэмээн үзсэн байдаг. Ийм хувилбар нь зөвхөн утга салаалахаас үүсэх төдийгүй бүтээврээр илрэх нь буй. Жишээ нь: дурын бүтээвэр буюу дэд бүтээвэр (субморф) нь тухайн нэг үед нэмэлт бүтээвэр болж, найруулгын ялгаа бүтээх шинжтэй байдаг. Монгол хэлний дайта-дайла, эгүрид-абурид, бөгж-бөлжиг гэх мэтээр авиа-утгалбар, үе-утгалбар сэлгэн үглэврийн хувилбар үүсгэжээ. Мөнгөжүү-гөжүүд, гажуу-гажууд, зөрүү-зөрүүд, үхлүү-үхлүүт, хол-холхи гэх мэтээр аль нэг бүтээвэр нэмж орсон ч уул үгээсээ утгын хувьд төдий л үл ялгарах ажээ. Иймд эдгээрийг дэд бүтээврээр үүссэн хувилбар гэж болно” гэжээ.

Монгол судлаач Г.Ц.Пюрбеев монгол хэлэн дэх дэд бүтээвэр илрэх сонирхолтой үзэгдлийг ажиглан тайлбар, зүүлт хийсэн байна.⁷ Тэрээр дэд бүтээвэр бүхий үгсийг “нэг үндэст ойролцоо нэр” хэмээн нэрлэсэн юм.

—н дэд бүтээврийн үүрэг, найруулгын онцлог

³ Д.С.Ворт, “Морфология славянского слово образования”, American contributions to the VII International congress of Slavists I.The Hague, 1973, p. 387.

⁴ О.С.Ахманова, “Словарь лингвистических терминов”, М., 1969, стр. 460.

⁵ Ш.Туяа, “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005, 28-р тал.

⁶ Б.Идэрбаяр, “Монгол хэлний төсөөт үг”, Уб, 2005. 14-р тал.

⁷ Г.Ц.Пюрбеев, “Об одном типе синонимовв современной монгольской терминологий”, ШУА, ХЗХ “Нэр томьёо судлал”, Уб., 2006, 60-68-р тал.

Наргиа-наргиан, долгио-долгион, хүсэл-хүслэн, халуу-халуун, цоорхой-цооронхой, ноорхой-нооронхой зэрэг үгсэд нэрээс нэр үг бүтээх “-н” бүтээврийг нэмэвч утга үл ялгах тул дэд бүтээвэр хэмээн нэрлэлээ. Дэд бүтээвэр “-н”-ийн хувьд дагавраас гадна оруулбараар илэрч байна.

Оросын эрдэмтэн Т.А.Бертагаев монгол хэлэнд оруулбар бүтээвэр илэрч байгаа тухай дурдахдаа “Монгол хэлний дуньсян, баоань аялгуунд оруулбар байдаг гээд хулан-хуцулаган (улаан-маш улаан), шыра-шыцураган (шар-шав шар) гэхэд “-пу” оруулбар нь хүч нэмэгдүүлсэн утгатай байгаа бол баоань хэлэн дэх фелан-фабалган (улаан-улаавтар), шира-шибэрги (хар-харавтар) гэхэд “-ба” оруулбар нь багасгасан утга илэрхийлж байна” гэжээ.

Мөн доктор, профессор М.Базаррагчаа⁸ “« Б » хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь” өгүүлэлдээ “Монгол хэлнээ CV гэсэн язгуур ка-ка- (хах), кө-кү- (хөхөх), кө-ки- (баясах), ко-ку-ий- (хохойх), ку-ка/у-ий-(хухайх), кэ-кэ-ий- (хэхийх-ихэмсэглэх) гэх мэтээр давтан үг бүтээдэг. Энэхүү давтамал язгуурын завсар “б, г(э), р, л, м, н, (нг)” гийгүүлэгч буюу авиа-утгалбар шурган орж, нэлээд өөр утга бүхий үг бий болдог” хэмээн монгол хэлэнд оруулбарын аргаар үг бүтсэн жишээг дурджээ. Үүнд: ховх, хавх, хав, хаван, хөвх (хөндий, ухмал газар). Цааш нь “орулбар “б” утгалбар нь өнгө зүс заасан үгсийн язгуурыг давтахдаа хоосон зайг алгасан “у-б ула-га-н” (ув улаан),”кө-б кө-кэ”(хөв хөх) гэхчлэн утгварын үүрэг гүйцэтгэнэ” гэжээ. Ийнхүү монгол хэлний оруулбар бүтээвэр нь тийм нийтлэг биш ч гэсэн зарим нэг үгэнд илэрч байна гэж үзэж болохоор байна. Цоорхой-цооронхой гэсэн үгийг тайлбар толиудад хэрхэн үзсэнийг харьцуулбал, Я.Цэвэлийн тольд цоорхой гэсэн үгийг “юмны цоорч онгорхой болсон газар” гэж тайлбарлаад “цооронхой” гэдэг үгийг тайлбарлаагүй байна⁹. Харин И.Дамбажавын тольд¹⁰ цоорхой, цооронхой гэсэн үгсийг хоёуланг нь “юмын цоорч, нүх сүвтэй, онгорхой болсон газар” хэмээн тайлбарлажээ. Өвөр монголын эрдэмтэн Ц.Норжин¹¹ “цоорхой”-г “цоорхой буюу ерөөс нүхтэй, зай завсартай”, гээд “цооронхой”-г “нэгэнт цоорхой болсон байгаа” хэмээн дээрх эрдэмтэдтэй ерөнхийдөө адил утгатай боловч цоорсон шалтгаанаар нь ялгаатай хэмээн үзжээ.

Эрдэмтэн Д.Бадамдорж¹² нооронхой, цооронхой гэх мэт үгийг туранхай, эцэнхий, татанхай, түлэнхий, ерөнхий, бөөрөнхий зэрэг үгтэй адил “-нхай⁴” гэсэн дагавраар “дутмаг шинж”-ийн утга илтгэнэ гээд эдгээрийг төрөл, утгын талаас нь авч үзжээ. Нэрээс нэр үг бүтээх “-н” оруулбар дэд бүтээврийг бусад үг бүтээх “-н”дагавраас ялгаж ойлгох нь чухал юм. Үүнд: Д.Бадамдоржийн “-н” дагаврыг утгаар ангилсантай харьцуулбал:

- Модон, усан, үсэн гэх мэт юм хэмээх утга;
- Ногоон, цагаан, улаан, ариун хурдан гэх мэт шинж тэмдгийн утга;
- Эрин, зуун, жаран гэх мэт цагийн тодорхой хугацааг илтгэсэн утга;
- Нэгэн, гурван гэх мэт тоон тодотгол утга;

⁸ “МУИС-ийн МСС-ийн эрдэм шинжилгээний бичиг”, XIV боть, 1999. 5-р дэвтэр, 36-39-р тал.

⁹ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб, 1966.

¹⁰ И.Дамбажав, “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж”. УБ., 2005, 925-р тал.

¹¹ С.Норжин, “Mongyol kelen- u toli” Koke qota,1999.

¹² Д.Бадамдорж, “Монгол хэлний утга судлал”, Уб., 2001. I боть. 84-р тал.

- Дархан, хүргэн, охин, эзэн гэх мэт хүн төрөлт гэх утга;
- Манин, тайган, асман, хусран гэх мэт дутмагийн утга;
- Хойтон, ноднин, өвөлжин, зунжин гэх мэт хугацааны утга;
- Чуулган, тэмцээн, цуглаан, хөдөлгөөн гэх мэт хам олон чуулан үйлдэхийн утга зэрэг нь тухайн үндсийн утгын дагуу бүтсэн юмын утга илтгэх бөгөөд “-**н**” дэд бүтээвэртэй адил бус бөгөөд ус-усан, ногоо-ногоон, зуу-зуун, хойт-хойтон гэх мэтээр “-**н**” дагавартай, дагаваргүйгээр хэрэглэгдэх үед тэнцүү хэмжээний үүрэг, утга илтгэж чадахгүй юм. Жишээ нь: “*Овоохойд дэн асаж, дотор нь нооронхой хувцас нөмөрсөн ухаантай, түвшин царайтай эмгэн гайхан чагнаснаа овоохойгоос гарч Мөнхөөд ойртов*” (Ч.О.164) гэсэн өгүүлбэрт буй нооронхой гэсэн үг нь И.Дамбажав, Ц.Норжин нарын тольд ноорхой гэсэн үгийн тайлбартай адил “Хувцас бүрээсний ихэд урагдаж навтарсан байдал адил” гэсэн утгаар орсон байна.

Цоорхой, цооронхой гэсэн үгийн хувьд мөн адил байна. Тухайлбал: “*Чи сая гэр дээрээс юугаа хуу татаад далд хийв? гэж амар мэндийг асуух завдалгүй тулгаж цоорхой эсгийн завсраар бараан дороос хулгайгий нь бариулж цухуйж байсан хонины арьсыг нүдээр ширвэн харвал тэр эхнэр хариу өчрүүн...*” (Б.Р) гэсэн өгүүлбэрт буй цоорхой гэсэн үг нь цооронхой гэсэн үгтэй адил “Юмын цоорч, нүх сүвтэй болсон газар” (И.Д.925) гэсэн утга илэрхийлж байна.

Мөн түүнчлэн хүсэл, хүслэн гэхэд -н дэд бүтээвэр илэрч байна. Жишээ нь: “*Үнэндээ надад очих хүсэл хязгааргүй байсан юм*”(Д.М.120).

Бэр хүргэх бэлэгтэй

Бялхан халгих хуримтай

Дэр нийлүүлэх жинтүүтэй

Дээгүүр доогуур хүслэнтэй. (Да.Н.304)

гэхэд хүсэл-хүслэн хоёр үг нь хоёул Я.Цэвэлийн тайлбар тольд тайлбарласан шиг “ямар нэг юманд дурших, бахдах мэтээр эрмэлзэх, мөрөөдөх сэтгэл”(хүсэл), “юмыг эрмэлзэх, мөрөөдөх сэтгэл”(хүслэн) гэсэн утгаар оржээ. Хоёр үгийг жишээнд орсон байдлыг харьцуулахад хүслэн гэсэн үг нь хүсэл гэсэн үгээ бодвол илүү нарийвчилсан, хүч нэмэгдүүлсэн утга илэрхийлж буй мэт үл ялиг ялгаа харагдаж байна.

Наргиа, наргиан гэсэн үгсийг Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд “наргиж наадах, олныг хөгжөөхдөө гарамгай”(наргиа), “хөгжөөн цэнгээнт байдал”(наргиан)¹³ гэж тайлбарлажээ. Жишээ нь: “*Энэхүү наргиан нөгөө түнш багачуудын инээдийг хүргэхийн ихээр хүргэж, хөгжөөхийн ихээр хөгжөөжээ*”(С.Д.13). Мөн “*Сайхан зантай, наргиа залуутай би хамгийн түрүүнд танилцав*”(С.Б) гэсэн жишээг харьцуулахад наргиа гэсэн үг нь хөгжөөнч, наргианч шинж чанар заасан, наргиан гэсэн үг нь хөгжөөнт байдал гэсэн утга илэрхийлж байгаагаараа ялгаатай байна.

Долгио, долгион гэсэн үгсийг Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд “усны дээд өнгөн талд гарах давалгаа”¹⁴ гэж адил тайлбарлажээ. Жишээ нь: “*Өмнийн бүлээн салхинд хурган долгио үүсэж, номин өнгөт униарт тэнгэрийн савсалгаас тасралтгүй хөөцөлдсөн нялцгай замаг, хорхой наалдсан чулуун даланд хальтран буцна*”(С.Э.105)

¹³⁾ ШУА, ХЗХ, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Уб, 2008, 1342-р тал.

¹⁴⁾ ШУА, ХЗХ, Мөн тэнд, Уб, 2008, 699-р тал.

гэхэд буй долгио, “Долгион эвхрэн, Долгион шуугина”(Б.Я) гэхэд буй долгион гэсэн үгс нь “усны дээд өнгөн талд гарах давалгаа” гэсэн утгаар оржээ.

Халуу, халуун гэсэн үгсэд мөн дэд бүтээвэр илэрч байна. Жишээ нь: “*Мөнхүү тавдугаар зэргийн жинс, отгоор шагнуулагчдын дунд нэрээ гарсныг сонсоод Лодой баяны нүүр халуу оргиж, чих шуугиан дүг дүг лугшив*” (Б.Р) гэхэд буй халуу, “*Урдаас халуун дүүгэн ханхийж, гацуун утаа хамар шархиртал хатгалаа*” (С.Д.53) гэхэд буй халуун гэсэн үгс нь адил “илч” гэсэн утгаар оржээ.

ДУГНЭЛТ

Гадаад хэлбэрээрээ үгийн нэгэн утгат хэсэг буюу бүтээвэр болон харагдах боловч үнэндээ утга үл ялгах, эсвэл маш бага утга ялган найруулга, хэрэглээнд тодорхой үүрэг гүйцэтгэх, нэмэлт бүтээвэр шинжтэй, үгийн хувилбар үүсгэж байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр гэнэ хэмээн тодорхойлж болно.

Энэхүү өгүүлэлд “-н” бүтээвэр бүхий цоорхой-цооронхой, ноорхой-нооронхой, наргиа-наргиан, долгио-долгион, хүсэл-хүслэн, халуу-халуун зэрэг үгсийн үүрэг, найруулгын онцлогийг харьцуулж тодорхойллоо.

НОМЗҮЙ

1. Ахманова О.С., “Словарь лингвистических терминов”, М.,1969.
2. Бадамдорж Д., “Монгол хэлний утга судлал”, Уб., 2001, 1-р дэвтэр МУИС-МСДС, ЭШБ№13 (139), Уб.,1998.
3. Базаррагчаа М. “«Б» хэмээх оруулбар утгалбар нь угтвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь”, МУИС, ЭШБ, XIV боть, (V дэвтэр), Уб.,1999.
4. Бертагаев Т.А., “Морфологическая структура слова в монгольских языках”, М.,1972.
5. Болд Л нар/Ред/, ШУА, ХЗХ, “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”, Уб, 2008.
6. Ворт Д.С., “Морфонология славянского слово образование”, American Contributions to the VI International congress of slavists, I. The Hague.,1973.
7. Дамбажав И., “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж”, Уб., 2006.
8. Земская Е.А., “Современный русских язык”, М.,1973.
9. Идэрбаяр Б., “Монгол хэлний төсөөт үг”, Уб., 2005.
10. Кубрякова Е.С., “О типах морфологической членимости слов, Она же. Основы морфологического анализа”, М.,1974.
11. Лопатин В.В., “Русская словообразовательная морфемика проблемы и принципы описания”, М.,1977.
12. Моисеев.А.И., “Основные вопросы словообразования в современном русском литературном языке”.
13. Өнөрбаян Ц., “Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс”, Уб., 2000.

14. Пюрбеев Г.Ц., “Об одном типе синонимов в современной монгольской терминологий”, ШУА, ХЗХ, “Нэр томъёо судлал” №8, Уб., 2006.
15. Туяа Ш., “Үг бүтэхүйн утга зүй”, Уб., 2005.
16. Цэвэл Я., “Монгол хэлний товч тайлбар толь”, Уб., 1966.
17. Цэцэнцогт Ш., *Монгол үгсийн язгуурын толь*, Жан Жияа Кэу, 1988.
18. Чурганова В.Г., “О предмете понятия фономорфологий”(«Известия АН СССР. Серия литературы и языка» вып.4), М.,1964.
19. Шанский Н.М., “Исследования по современному русскому языку” (Издательство Московского университета), М.,1970.

ABSTRACT

Morphemes are the smallest individually meaningful elements in the utterances of a language.¹⁵ Thus the morphemes are all meaningful. There are many methods for forming new words in the contemporary Mongolian language and one of them is word formation by suffixes. New word is formed with connected suffix to its root. However, the exciting phenomenon that new word has no semantic meanings is emerged when suffix connected to word roots. In morphology, it is called sub morph.

The present article has reviewed the emerged meaning, structure and classification of those sub morphs in Mongolian language along with examples from the literature.

There are many concepts such as sub tune, sub pronunciation, sub meaning and sub part in the linguistics and “Submorph” the object of our study is considered as one of those concepts. It is subunit at the lingual morpheme level and generally this subunit has no particular semantic meaning when it connected to word roots, but minor variance in the applied stylistics. Therefore the subunit of lingual morpheme has the different definition and title for instance E.A Zemskaya, E.C Kubryakova “Sub morph”, N.M Shanskii “Affecksoide”, D. S. Vort “Morpheme no semantic meaning”, V.V Lopatin “redundant” or “insert” morpheme, G. O Vinocur “variation of root”, A. I Moiseev “quasi-morpheme” etc. Although these titles seem different, they have defined the main characteristics of sub morph.

Many sub morphs namely as -га⁴, -с, -м, -ж, -ч, -р, -аа⁴, -ц, -н, -т are found in Mongolian language, among them -га⁴, -с suffixes are mostly used in word formation. As summarized from the preceding reviews and studies from the named scientists, sub morphs emerged in Mongolian language morphology is become the attractive object of the study.

¹⁵⁾ Pual R.Kroeger, *Analyzing Grammar (An Introduction)*, New York, 2005, p. 12.